



ХЭНТИЙ АЙМГИЙН ДАДАЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 02

Баян-Овоо

Тайлан хэлэлцсэн тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 27.5.21 дэх заалт, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын Цагдаагийн хэсгийн 2025 онд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэв журмыг хамгаалах чиглэлээр хийсэн ажлын хэрэгжилтийг хангалттай гэж үзсүгэй.

2.Сумын ИТХ-ын төлөөлөгчдөөс гарсан саналыг 2026 оны үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж ажиллахыг сумын хэсгийн төлөөлөгч, дэслэгч (Г.Билгүүн)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.БАЯСГАЛАН

010600045

